НБХ-Наранэрдэнэ
Судлаж
танилцуулах
IX/30
2024

**МОНГОЛЫН ХАРААГҮЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ХОЛБОО**

Дорнод аймаг дахь салбар зөвлөл
Хэрлэн сум 4-р баг
Хүний хөгжлийн ордон
Утас/Факс: 70582333, 89764600
Email: osohbayar1976@gmail.com

2024-09-25 № 04
танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд хараагүйн спортын төрлийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, спортод авьяастай тамирчдыг нээн илрүүлэх, харилцан туршлага солилцох, өрсөлдөх ур чадварыг дээшлүүлэн улс тив дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг нээн илрүүлэх зорилготой ХАРААГҮЙ ИРГЭДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “2024 СПОРТЫН ИХ НААДАМ”-д аймгаа төлөөлөн 10 тамирчдаа авч очин оролцох хүсэлтэй байгаа тул унаа, хоолны зардалын тусламж үзүүлнэ үү. Тэмцээн 2024 оны 10 сарын 3 – 8 ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдана.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ХАРААГҮЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН: Г.ӨСӨХБАЯР

ХАРААГҮЙЧҮҮДИЙН ... ДОРНОД АЙМАГ ДАХЬ САЛБАР ... 1010964 ХАК1320 №06 ... ХОЛБОО

Б. Төмөрбүгүүдүү

Одоогоор ... ээ үүсвэрээ судалж санал гаргах
2024.09.30

Батлав:
МХҮХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга ___ Ч.Очиррэнчин

УЛААНБААТАР ХОТ МОНГОЛЫН ХАРААГҮЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ХОЛБОО ГҮТББ

# ХАРААГҮЙ ИРГЭДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ "2024 СПОРТЫН ИХ НААДАМ"-ын УДИРДАМЖ

1. **Зорилго:** Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд хараагүйн спортын төрлийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, спортод авьяастай тамирчдыг нээн илрүүлэх, харилцан туршлага солилцох, өрсөлдөх ур чадварыг дээшлүүлэн улс тив дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг нээн илрүүлэхэд уг наадмын зорилго оршино.
2. **Спортын наадам зохион байгуулагдах газар, хугацаа:**
   2024 оны 10 сарын 05-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдах болно.
3. **Зохион байгуулах байгууллага:**
   1. Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо
   2. Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дэргэдэх спортын зөвлөл
4. **Спортын наадмын төрөл, зай, жин:**

| № | Спортын төрөл | Явагдах газар, хугацаа |
|---|---|---|
| 1. | **Хонхот бөмбөг**<br>- Эрэгтэй: нэг багт 4 тамирчин<br>- Эмэгтэй: нэг багт 4 тамирчин | 2024 оны 10-р сарын 05, 06-ны өдрүүдэд 09:00 цагаас<br>Хан-Уул спорт зааланд |
| 2. | **Жудо**<br>- Эрэгтэй: -60, -66, -73, -81, -90, +90 жингүүд<br>- Эмэгтэй: -48, -52, -57, -63, -70, +70 жингүүд | 2024 оны 10-р сарын 7-ны өдөр 15:00 цагаас<br>МХҮХ-ны спорт зааланд |
| 3. | **Шоудаун (Showdown)**<br>- Эрэгтэй,<br>- Эмэгтэй, | 2024 оны 10-р сарын 08 -ны өдөр 09:00 цагаас МХҮХ-ны спорт заал |
| 4. | **Хөнгөн атлетик:**<br><u>1. Гүйлт:</u><br>- Эрэгтэй: 40 хүртэлх нас (1500м),<br>- Эрэгтэй: 40-с дээш нас (5000м)<br>- Эрэгтэй: хөтлөгчтэй ангилал (3000 м)<br>- Эмэгтэй: 40 хүртэлх нас (1500м),<br>- Эмэгтэй: 40-с дээш нас (5000м)<br>- Эмэгтэй: хөтлөгчтэй ангилал (1500 м)<br><u>2. Бөөрөнцөг түлхэлт:</u><br>- Эрэгтэй: 7кг 250гр, | 2024 оны 10-р сарын 07-ны өдөр 09:00 цагаас<br>Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд |

| | |
|---|---|
| - Эмэгтэй: 5кг, | |
| **Шатар**<br>- Эрэгтэй,<br><br>- Эмэгтэй, | 2024 оны 10-р сарын 05-ны өдөр 09:00 цагаас МХҮХ-ны сургалтын танхим<br>2024 оны 10-р сарын 06-ны өдөр 09:00 цагаас МХҮХ-ны сургалтын танхим |
| **Даам**<br>- Эмэгтэй,<br><br>- Эрэгтэй, | 2024 оны 10-р сарын 05-ны өдөр 09:00 цагаас МХҮХ-ны сургалтын танхим<br><br>2024 оны 10-р сарын 06-ны өдөр 09:00 цагаас МХҮХ-ны сургалтын танхим |
| **Гар барилдаан**<br>- Эрэгтэй: -75, +75 жингүүд<br>- Эмэгтэй: -63, +63 жингүүд | 2024 оны 10-р сарын 08-ны өдөр 15:00 цагаас МХҮХ-ны сургалтын танхим |

5. **Спортын наадмын бүртгэл, мандат олголт:**

Бүртгэл 2024 оны 10 сарын 03-ны өдрийн 16.00 цаг хүртэл явагдана. Оролцох баг, тамирчид комиссын шийдвэрийн хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар, мандатын үнэ 10000 төгрөг, 3x4 хэмжээтэй 1% цээж зураг, харьяа байгууллага буюу салбар зөвлөлийн тамгатай албан бичгийг бүрдүүлэн ирж мандат авна.

6. **Техникийн зөвөлгөөний хурал:** 2024 оны 10-р сарын 04-ны 16:00 цагаас МХҮХ-ны хурлын танхимд техникийн зөвлөгөөний хурал, спортын төрөл тус бүрийн сугалааны үйл ажиллагаа явагдана. Мөн онлайнаар явагдана.
7. **Тамирчдын хувцаслалт:** Оролцох баг, тамирчид хувцас, хэрэглэл, энгэрийн дугаар, нүдний хаалт, жудогийн өмсгөл зэргийг урьдчилан бэлдэнэ.
8. **Ёслолын ажиллагаа:** Наадмын нээлтийн ажиллагаа 2024 оны 10-р сарын 05-ны өдрийн 09:00 цагаас МХҮХ-ны спортын зааланд болно.
9. Тус спортын наадмын хаалтын үйл ажиллагаа, шагнал гардуулах ёслол 10-р сарын 09-ний 18:00 цагт болно. Тамирчдад зориулсан өдөрлөг цэнгүүн ХХХСХТ-ийн соёлын танхимд болно.
10. **Тэмцээний шагнал:** Төрөл тус бүрд 1, 2, 3 дугаар байр эзлүүлж, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагнал олгоно. Багийн дүнг эзэлсэн байр, медалийн чанараар үнэлж цом, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

Улсын аварга шалгаруулах “Хонхот бөмбөг” ийн тэмцээнд оролцох

баг тамирчдад шаардагдах төсөвийн задаргаа

| № | Зардлын нэр | Хүний тоо | Нэгж үнэ | Нийт хоног | Мөнгөн дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Унааны зардал | 4 | 61800 | | 494,400 |
| 2 | Хоолны зардал | 4 | 40000 | 4 | 640,000 |
| 3 | Буудлын үнэ | 4 | 240000 | 4 | 960,000 |
| 4 | Мандатны үнэ | 4 | 10000 | | 40,000 |
| 5 | Нийт мөнгөн дүн | | | | 2134,400₮ |

МХҮХ-НЫ ДОРНОД АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН ТЭРГҮҮН: Г.ӨСӨХБАЯР

МОНГОЛЫН ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХОЛБОО
ДОРНОД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ
1010864
ХАн1320
№08